

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шагдарын Содномдорж	Дугаар	L254
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Ханбогд сум
Төрсөн газар	Ханбогд сум	Төрсөн он	1923
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Өлгий хийд	Сүм хийдийн дугаар	ДГМН 095
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

### Дорноговь аймгийн Мандах сумын Өлгий хийд

Гантулга: Өлгий хийдийн тухай ярилцлага хийх гэж байна. За Содномдорж гуай та өөрийгөө танилцуулна уу, аль хийдэд шавилан сууж байсан бэ, хэдээс хэдэн оны үед, хэдэн настайдаа хэдэн жил суусан тэр талаараа ярина уу?

Содномдорж: Би тав зургаан настай байхдаа Санхирын хийдэд эцгийгээ дагаад тэнд байж байсан.Тэгээд арван нэгэн настай Өлгий хийдэд очсон.Өлгий хийдэд зургаан жил, зургаа өвөлжсөн.Зун би сууж байгаагүй.Зургаа өвөлжсөн.Тэгээд 1937 оны үхэр жилийн арван нэгэн сард Өлгий тарсан шиг санаж байна аа.Өлгий мянган ламтай.Тэндээс нь яг мөнгө төлдөг, данстай лам нь 666 байсан гэж ярьдаг юм.Найман дацантай ийм хийд байсан.За сайн эмч, сайн зурхайч, сайн уншаач, сайн чойрчин гэвш гэх мэтийн олон тийм эрдэмтэй улстай байсан.Тэр гол төлөв нь сүүлийн үед баригдаад явсан байх аа.

Гантулга: Нэрийг нь өөрөөр юу гэж нэрлэж байсан бэ?

Содномдорж: Жанчивдэчинлэн гэж байсан шиг санадаг юм.

Гантулга: Хэзээ хэн байгуулсан хийд гэж байгаа билээ?

Содномдорж: Даяанч гэж ганц бадарчин лам тэр Өлгий уулын энгэрт агуйд даяан хийж байгаад тэгээд тэрэн дээр байгуулсан юм гэж дуулсан.

Гантулга: Хуучин захиргааныхаа харъяаллаар аль аймгийн аль хошуунд харъяалагдаж байсан бэ?

Содномдорж: Мэргэн Вангийн хошуунд хамаарч байсан.

Гантулга: Тэр Өлгий хийд байсан газрын нэр усыг хэлвэл?

Содномдорж: За одоо Өлгий уул л гээд байдаг юм ш дээ. Тэр жинхэнэ овооных нь нэрийг мэдэхгүй байна.

Гантулга: Газарзүйн байрлалаар тэр байгаа газар нь уул хадтай газар уу, тэгш талархаг?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Содномдорж: Яах аргагүй өндөр уулын энгэр дээр бүр наалданги барьсан. Дундуураа булаг урссан тийм хийд байсан.

Гантулга: Ойрхон тахилгатай рашаан хад, уул овоо байсан уу?

Содномдорж: Өөрийнх нь тэр хойд байгаа, өөрсдөө тахидаг тахилгатай овоо байсан юм аа.Тэрүүнд одоо хүн хайртай ямаагаа авчирч тавиад тэгээд гуч дөчин ямаа ил л явж байдаг.Шөнө ирж сүмийн нөмөрт унтаад л өдөр тэр овоон дээр гарч иддэг. Чоно нохой идчихдэггүй тийм ямаатай байсан.Одоо аргаль нь тийм болчихсон юм гэнэ лээ.Хүнээс ч айдаггүй, ирээд л булаг мулагнаас нь үүж байдаг, хүн байж байхад.Одоо аргаль нь тэр ямааны оронд тийм болчихсон юм байна гэж би ойлгодог.

Гантулга: Өлгий хийдийн одоо ерөнхий тэг зураг гэж байдаг болов уу?Фото зураг юм уу, гараар зурсан?

Содномдорж: За ер мэдэхгүй байна.Одоо байгаа тэр байсан лам нар нь байж мэднэ. Тэр би зураг нь байдаг юм гэж би нэг дуулж байсан. Одоо тэрнийг надад хэлэх юм алга, мартчихаж.

Гантулга: Ойролцоо байдаг сүм хийдүүдийг нь нэрлэвэл?

Содномдорж: Тэнчээ Хоньчийн хийд л гэж байсан.Тэрнээс өөр тэр хавьд байхгүй. Манлай, Ханбогд, Хатан , Мандах дөрвөн сумаас дандаа зуу, зуун километрийн дунд цөлд байсан юм.

Гантулга: Тэр цогчин дуганы гол шүтээн нь ямар бурхан байсан бэ?

Содномдорж: Арьяабал гээд ард нь жижигхэн сүм бариад тэрэнд нь гол шүтээн нь байсан.

Гантулга: Хичнээн лам хуваргатай хийд байсан?

Содномдорж: Мянган ламтай гэж байсан. Дуганыг нь хуруулаад ирэхэд мянган лам хүлээж аваад гардаг байсан гэж байгаа юм.

Гантулга: Хутагт хувилгаан алдартай лам нараас нь дурдвал, ямар ямар улсууд байсан?

Содномдорж: За жинхэнэ нэрийг нь мэдэхгүй юм байна.Тэр үед ч одоо хэлдэггүй, цээртэй байсан учраас. Баруун лам, зүүн лам гэж хоёр хувилгаантай байсан юм аа.

Гантулга: Том унзад, цорж, гэсгүй ловон?

Содномдорж: Арван зургаан насандаа дархан унзад болсон дархан Самбуу гэдэг хүн Манлай суманд баригдаагүй үхсэн.

Гантулга: Хамба лам нь?

Содномдорж: Хамба лам нь Санжмятав лам гэж байж байгаад эхний үед баригдсан.

Гантулга: Цорж гэсгүй?

Содномдорж: Цорж лам нь Цагаан хадны аграмба нэртэй тэр хүнийг цорж ламаар суулгадаг байсан. Тэр хүн нь Өлгийд байнга байдаг хүн биш ээ.

Гантулга: Ловон, гэсгүй?

Содномдорж: Ловон нь, за ер нь одоо чойроо л голлодог байсан.Их чойртой хүнээ л одоо дээдийн хүн гэдэг. Хүрээний ангид Чогзов гэдэг лам байлаа.Манай ах дүү болох юм гэнэ лээ.Цэрэндорж гэж хүн байлаа, анги Цэрэндорж гэж. Шагдар гэж лам байсан юм.Тэгээд хүрээнд очоод суучихсан, Өлгийд хурал хурвал ирж хураад л

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэгээд л буцаад явдагтйим лам нар байсан. Ирсэн үед нь тэр хойд ууланд жалганд гэр бариад лам нар оочирлоод тогоо шанагыг нь барьчихдаг, хүн тасардаггүй тийм лам нар байсан.

Гантулга: Алдартай зурхайч, эмч, зураач, бурханч?

Содномдорж: За Маньдаагийн Ренчин гэж хүн байсан, эмч хүн.Дандаа хүнийг хутгаар, зүсдэг, ханадаг, хатгадаг.Тэгээд нэг хүний энэ судсыг хатгачихсан юм гэнэ лээ.Хайнга огтлоод .Тэгснээ зүсээд, судсыг нь гаргаж байгаад хоёр үзүүрийг нь мушгиад тэгээд буцаагаад нэгтгээд уячихсан гэж байгаа юм.Тэгсэн тэр судас аажмаар эрэлсээр байгаад тэгээд залгаад эдгэчихсэн юм гэдэг.Сонин байгаа биз, тэр.

Гантулга: Үнэхээрийн мундаг хүн юм аа?

Содномдорж: Тийм, үнэхээрийн чадалтай.

Гантулга: Гэлэн сахилтай хүн олон байсан болов уу?

Содномдорж: За ер нь хорь гучаас дээш насныхан дандаа гэлэн байсан байх.

Гантулга: Өлгий хийдийн дацан дугануудыг нэрлэвэл?

Содномдорж: Найман дацантай байсан, цогчин, чойр, дүйнхор, мамба, ламиран...

Гантулга: Гүнриг?

Содномдорж: Гүнриг, баруун зүүн ламын сүм гэж тэгээд найман сүм байсан.

Гантулга: Хичнээн суваргатай байсан бол?

Содномдорж: Суварга энэ тэнд бол нэг нэг суварга зөндөө байсан.Аа зүгээр хорин нэгэн суварга гэж тэр хөгөөс баруунтаа, Өндөр хөг гэж байдаг юм.Зүүн өмнө нь , өшөө хол явна, бараг км явж байж харьдаг.Тэрний баруунтаа хорин нэгэн суварга гэж байсан, дундхийг нь доогуур ачаа тэмээ багтдаг тийм суварга байсан юм. Хоёр талд нь арав арван намхан, газартайгаа үргэлж суваргатай.Одоогийнхоор бол ямар юмны хаалга,үндсэн уулын хаалга гэж ярьдаг билүү...

Гантулга: Ном барладаг байсан болов уу?

Содномдорж: Ном барладаг барчин улсууд байсан байх.Бурхан зурдаг Нилуунсандуй гэж лам байсан юм.

Гантулга: Зурхайч эмч?

Содномдорж: Зурхайч Цогжил зурхайч гэж байсан юм.Их сайн зурхайч, тэр долоон давхар санвай гэдгийг хийж байсан юм гэнэ лээ, би тэр хүнийг үзээгүй.Тэр надаас өмнө үхсэн байх аа даа.

Гантулга:Тэр дацан?

Содномдорж: Тэр сүүлд нь Чимэд зурхайч энэ тэр гээд зурхайч зөндөө байсан. Алдартай хүн нь байсан юм болов уу, мэдэхгүй.

Гантулга: Тэр дацан дуганууд нь ямар ном уншдаг байсан юм бол?

Содномдорж: Тэр өөр өөрсдийнхөө төрлийн номыг уншдаг.Ухаан нь цогчин гэдэг чинь цогчингоо хурдаг.Өвлийн адаг сарын хорин зургаанаас эхлээд шинийн нэгэн хүртэл хуучны хурал гэж дандаа хангал хурдаг.За дүйнхор нь дүйнхор хурдаг, ламиран нь ламиран хурдаг, мамба нь одоо тэр эмнэлгийн ямар ном

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байдаг юм тэрнийгээ хурдаг. Гүнриг нь голдуухан одоо тэр үхсэн хүний хойд талыг л хийдэг байсан болов уу даа. Гүнриг цохино гэж л ярьдаг байсан. Тийм л хурлууд байдаг байсан юм.

Гантулга: Жилдээ нэг болдог сар бүрийн шинийн найман, арван, арван тавны хурлуудаар ямар ном уншдаг байсан юм бол?

Содномдорж: За шинийн найман энэ тэр гэдэггүй, шинийн нэгэнд золгочихоод шинийн хоёрон шинийн гурванд магтаал хурдаг байсан юм. Тэгээд арван дөрвөн арван таванд магтаал хураад, арван зургаанд майдар эргээд тардаг: Шинийн гуравнаас арван тавныг хүртэл хурал хурдаггүй. Өнөө цогчингоо түслахгүй, өшөө жилийн ухрал хурдаггүй дандаа тийм сэрчихдэг газар байсан юм. Тэвэг өшиглөнө, тэгээд л хатуу харвана, тэгээд бас тэр нэг хийдийн шамбалын тоглоом гэсэн юмнууд байдаг байсан, та нар мэдэх үү? Тийм тоглоом, ийм үүчүүр мэтийн тоглоом, таа барина. За тиймэрхүү тоглоом арван таван хоног, за шинэлчихээд арван гурван хоног ч юм уу тэгж тоглодог. Тэгээд л арван дөрвөн, тавнаас юу яадаг хангал биш ээ, магтаал хурдаг. Тэгээд арван зургаанд майдар эргээд тэгээд хаврын хурал дуусах нь тэр ээ. Зүгээр тэр гадуур хийдүүд бол өөр өөрсдийнхөө хурлыг хурж л байна. Гэхдээ тэр тоглодог үед тоохгүй.

Гантулга: Тэр үед тэр цогчин дуганых л яах уу, бүх хийдээрээ тэгж...?

Содномдорж: Тэгнэ. Цогчин ч тэгнэ, Өлгий хийд хийдээрээ.

Гантулга: Цамын бүжиг?

Содномдорж: Цамын бүжиг тийм юм байдаггүй.

Гантулга: Майдар бол эргэдэг байсан уу?

Содномдорж: Майдар бол эргэнэ. Тэр арван зургаанд.

Гантулга: Сор залдаг байсан уу?

Содномдорж: Сор зална. Өвлийн адаг сарын хорин есөнд залдаг байсан шиг санаж байна. Өвөл хорин зургааны орой Дармаажанлав гэдгийг хийгээд, тэрэн дээр байсан бүх лам тэр цогчин сүмд цугладаг. Тэгээд багтдаггүй, чихэлддэг. Мөрний хоорондуур хивс хаяад чихэлддэг тийм байсан. Тэгээд битүүний шөнө тэр Лхам бурхнаа тахиад, Амаа бурхан ч гэдэг. Тэгээд өглөө нь цэдэр гэдгийг хураад шинэлдэг байсан.

Гантулга: Цогчин дугандаа бол цогчин уншлагаа л хийнэ, тийм ээ?

Содномдорж: Тэгнэ.

Гантулга: Жилдээ нэг болдог том хурал байгаа болов уу, наадамтай?

Содномдорж: Наадам ер нь хийж байгаагүй. Харин тэр дом тавьсан улс л лянх гэдгийг хуруулдаг. Тэр нь харин хэдэн настай хүн давхиж, тэр хийдээсээ хөөгддөг. Тийм ёстой, тэр лянх дом тавьсан улсууд. Тэгээд тэр баруунтаа Баянулаан гэж үс нь байгаа юм. Тэрний өмнө дэнж дээр асар шаагаад тэнд очиж хурлаа хурдаг. Хурлаа хурж байхдаа лам нар нь өнөө Өлгийнхөө томчуулдыг залдаг. Тэгээд тэд нар нь очиж тэр хуралд нь оролцоод ирдэг, тэгээд буцаж хурдаг тийм.

Гантулга: Ганжуур эргэдэг байсан болов уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Содномдорж: Ганжуур эргэж байхыг сайн мэдэхгүй байна.Зүгээр ганжуур данжуур гэж хоёр ном нь бол байсан.Есөн эрднээр бүтээсэн хоёр зуун хорин боть данжуур байсан.

Гантулга: Цагаан сарын хурал өвлийн адаг сарын хэднээс эхлээд...?

Содномдорж: Хорин зургааны оройноос эхлээд Дармаажанлав гэдгийг хураад тэгээд тэрнээс хойш энэ арван хаангалыг хурж байсан юм.

Гантулга: Тэгээд л шинийн нэгэн...?

Содномдорж: Шинийн нэгний биш ээ, одоо битүүний шөнө юм уу даа , гучны шөнө тэр Амаа бурхан гэдгийг хураад өглөө цэдэр хураад тэгээд шигнэлдэг байсан юм.

Гантулга: Тэгээд сороо залах уу? Урд нь өдөр нь сороо залах уу?

Содномдорж: Тэр хорин есний өдөр сороо зална. Тэр арван хангалаа уншаад хорин есний өдөр сороо залдаг байсан юм.

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдөр, Богд ламын дүйчэн өдрөөр ямар ном хурдаг байсан?

Содномдорж: Аа тэр Богд ламын гэж мэдэхгүй байна. Намрын дунд сарын арван долоонд Сайхан Гомбо гэж хурдаг.Тэр хурлаар бол их юм болдог л байсан.

Гантулга: Хайлан хурдаг байсан болов уу?

Содномдорж: Хайлан хурж байсан.Дөчин тав хоногийн хайлан хурдаг.

Гантулга: Гэлэн сахилтай хүмүүс голчилж байх уу?

Содномдорж: Гэлэн гэцэл холилдож хурдаг.

Гантулга: Нүгнээ сахидагш байсан болов уу?

Содномдорж: Нүгнээ сахиж байсан.Нүгнээгийн хийд гэж байгаагүй ээ. Тэр Аръяабалын сүмд чоого хураад нүгнээгээ сахидаг байсан.Би ч бас сахиж үзэж л байсан.

Гантулга: Цогчин дуган болвол өдөр бүрийн уншлагаасаа гадна сар жилийн гээд тусгай том номнууд хурдаг уу?

Содномдорж: Тэр зургаан жанлаваар эхэлдэг хурал чингь цогчингийн хуралд хурна ш дээ.

Гантулга: Өөр одоо шашны том зан үйлүүд жилд нэг хоёр юм уу, сардаа нэг хоёр болдог?

Содномдорж: Дүнчүүр маани хурдаг байсан, жилд нэг удаа долоо хоног.Тэгэхдээ тэр хорин нэгэн суварганаас хойхно асар бариад, тэндээ өдөр шөнөгүй маани уншаад тэгээд дүнчүүр маани хурдаг байсан. Тэрнээс өөр тэр хийдүүдийнх нь тогтмол хурлууд хурж л байсан байх, тэр үед.Надад нарийн хэлж мэдэх юм алга.

Гантулга: Майдар эргэвэл яаж эргэдэг байсан, тэргэн дээр Майдраа залчихдаг байсан уу, лам нар дамнаад хийдээ гороолж эргэдэг байсан уу?

Содномдорж: Лам нар нь дамнаад явдаг байсан , тийм жуузтай, жуузныхаа хоёр талд ногоон морьны толгой хүзүүнийх нь угаар хадчихсан.Хадаатай, тэгээд дотор нь майдраа залаад бүдүүн их хоёр модон дээр дөрвөн их үзүүр гаргаад тэгээд тэрнийгээ лам нар ,залуучууд мөрлөөд .Тэгээд майдар эргэдэг байсан.

Гантулга: Хийдийн дуган дацангуудыг ямар материалаар барьсан байдаг юм бол? Модоор уу, тоосгоор уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Содномдорж: Дандаа тоосгоор.Намайг, би чинь тахиа жилийн хавар гарсан гэсэн. Тэр яг тахиа жил тэр цогчин сүмийг барьсан юм гэнэ лээ.Лувсанцэдэн гэж энэ Манлайгаас зүүн хойно Нярга хайрхан гэж байгаа.Тэнд нутагтай Лувсанцэдэн гэж баян хүн байсан юм гэнэ лээ.Хоёр зуун ботготой ингэтэй, гурва зуун хээлтэй ингэтэй тэгээд цаана нь сувай тэмээтэйгээ мянган тэмээтэй байсан юм байгаа биз дээ.Тэр хүн зуун тэмээ унаад гамин туудагийн хавар хүрээнээс наашаа мод ачуулсан.Өнөө тээсэн банди нар нь тэмээгээ тавьчихаад хоолоо хийж идчихээд унтаж байсан, гамин тэмээгий нь хөөгөөд явчихсан.Тэгээд тэр баян хэд хүргүүлсэн.Тэмээгүй боллоо, мод ирэхээ байлаа гэж тэгсэн. Тэмээ яахав ээ, нэг жилийн төл.Одоо хон байхгүй, тэр мод яаж авчирна гэж байсан.Тэгээд хон барьж байж авчирсан л юм гэнэ лээ.

Гантулга: Сүм хийдийн хэлбэр дүрс нь дөрвөлжин байсан уу?

Содномдорж: Дандаа дөрвөлжин. Ганцхан тэр дүйнхорын биш ээ, гүнригийнх дугуй байсан.Модон хүрэн будагтай сүм гэх юм уу даа.Гэр нь одоо энэ настны байр, үүлзалтын байр эд нар шиг л тийм хэлбэртэй том модон гэр.

Гантулга: Гавжийн дамжаа, домын дамжаа барьдаг байсан гэсэн үү?

Содномдорж: Домын дамжаа...

Гантулга: Аграмбын дамжаа барьдаг байсан уу?

Содномдорж: Аграмбын дамжаа барина.

Гантулга: Маарамба?

Содномдорж: Дүйнхор дээр, маарамба байхгүй.

Гантулга: Энэ дамжаа барихад ямар хугацаа хэрэглэдэг байсан бэ?

Содномдорж: Гавжийн дамжаа бол голцуухан ес хоног.Хавар цагаан сарын дараа цагаан сарын дамжаа гэж, нэг хүн гурван хоног ном хэлхдэг, гурван хүн ес хоног ном хэлхдэг байсан.

Гантулга: Нэг удаадаа бол гурван хүн л ордог байсан уу?

Содномдорж: Нэг удаадаа бол гурав. За ганц нэг хоёр хүн ордог байсан байх.Тэр чинь үхчихдэг, барьдаг бас юм байдаг юм байна лээ л дээ.

Гантулга: Чойрын исчаа нь ямар исчаа нь ямар исчаа байсан бэ?

Содномдорж: За тэрийг мэдэхгүй.

Гантулга: Хичнээн зиндаатай байсан , олон зиндаатай байсан уу?

Содномдорж: Олон зиндаатай байсан.Тэр зуун гучин есөн жил болсон гэхэд бол бараг зуугаад жил нь ч юм уу, дал наян жил нь жоохон байсан юм байгаа биз дээ. Тэгээд томорсон, сүүлдээ мянган лам болсон. Жилд нэг гучаад лам ирдэг.

Гантулга: Өлгий хийд ер нь бусад ойролцоо хийдүүдтэйгээ ямар холбоо харилцаатай байсан, одоо хүрээ ч юм уу?

Содномдорж:Хүрээтэй бол лам нар нь ирж очдог холбоотой байсан. За бусад жижиг хийдүүдэд зүгээр тэр нутгаас Өлгийд ирж суусан лам нар ирж очдог, хурлыг нь хурдаг тийм байсан.Хөдөөгийн жаахан хийдүүд бол

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

жилд хоёр юм уу, хурал хурна ш дээ.Тэрүүнд болвол тэр өөринхөөсөө Өлгийд очиж суусан лам нар одоо нэлээн номтой тэр хийдэд байснаасаа давуу болчихсон байх юм шүү дээ. Тэгээд л ирж хурчихаад яваад өгдөг.

Гантулга: Аа тийм л холбоотой, ер нь жишээлбэл аль хошууны аль хийдээс ирээд , тэндээ буцаж...?

Содномдорж: Энэ Дорноговь аймгийн харъяат Мэргэн вангийн хийдийн хошуу даа. Энэ зүүнтээ Цагчир гэж байсан юм, Салгир гэж байсан юм, тэрний зүүнтээ Хоньч гэж байна. Тэгээд тэр хойгуур Мандахын нутаг юм уу, Манлайн нутаг юм уу Засгийн шүтээн гэж байсан юм. За энэ лав тэр хийдийг тойрсон дөрвөн хийд байсан байх. Энэ Алаг Вэйгээс ирсэн лам очиж л байсан байх.

Гантулга: Энэтхэг, Төвд рүү лам нар явдаг байсан уу, Төвд Энэтхэгээс том лам нар ирдэг байсан болов уу?

Содномдорж: Том лам нарыг ирснийг би мэдэхгүй ээ.

Гантулга: Хэдэн жастай байсан бол?

Содномдорж: Найман жастай.

Гантулга: Мал толгой олон байсан болов уу, хөрөнгө мал?

Содномдорж: За мэдэхгүй.Өвөл лаг ший, нэг цэрэгт орно гэдэгт л олон үхэр түүж ирээд л алж байсан байгаа юм.

Гантулга: Лам нарынх нь орон сууц юунд байдаг байсан бэ, гэр хашаа байшинд уу?

Содномдорж: Голцуухан гэр.

Гантулга: Аймагладаг байсан уу, хүрээ шиг?

Содномдорж: Үгүй.

Гантулга: Тэгээд л тойроод л хийдээ тойроод?

Содномдорж: Тэгээд байж байдаг.

Гантулга: Цож лүйжинч лам нар байдаг байсан уу?

Содномдорж: Гомбосүрэн гэж ганцхан лүйжинч лам байсан юм гэнэ лээ. Өлгий ичнь улаан үндэснийхэн биш байсан болохоор лүйжин байдаггүй юм.Тэгээд борооноор би айлд нэг давхиад очсон.Тэр зүлгийг нь бүтээчихсэн. Бороонд бүтээсэн л юм байгаа биз гээд орсон чинь тэр зах Гомбосүрэн гэдэг хамрынх нь бага нь байхгүй юм шиг тийм лам байсан. Тэр хүн бол лүйжин тавьдаг байсан. Лүйжин мэддэг хүн байсан л юм байна лээ.

Гантулга: Хандмаа гэж байсан болов уу?

Содномдорж: Байгаагүй.

Гантулга: Та одоо лам байхдаа багшийнхаа гэрт суудаг байсан уу, тусгай?

Содномдорж: Багшийнхаа гэрт суудаг.Тогоог нь барьдаг.

Гантулга: Өдөр бүрийнхээ, өдөр тутмын амьдралаа өглөө эрт босоод орой унтах хүртлээ юу хийдэг байснаа нэг ярьж өгөхгүй юу?

Содномдорж: За тэр км хэртэй газартаа хогоо хаядаг юм. Том хөндөө хогоо хийж тэрнийг хаяна.Баянулаан гэж барагтаа хоёр км лав бий байх.Гурав хүрч байна уу, үгүй юу.Тэндээс модон хувингаар ус үүрнэ. Манай багш их

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аж ахуйч, тэмээ мал их яадаг.Тэрний хог сагийг нь арилгана.Тэр тэмээг аваачиж усална.Өдөр тэрийгээ тавиад явуулна.Баруун сүхайн хонгор гэж байдаг юм.Тэр хонгорт тэр тогтоно. Орой явж авчирна.Тэгээд л шөнө тэмээ хашаан дотор тэнэж байгаад л хоргол бутраачихна.Тэрнийг нь маргааш нь түүж авя түлшинд хэрэглэнэ.Хогийг нь дэрсэнл боож байгаад хашааны дотор талыг нь туучуурдана, хогийг нь цэвэрлэнэ.: Манай багшийнх их ажилтай.

Гантулга: Номоо хэзээ нь үзэх үү?

Содномдорж: Ном одоо өглөө нэг хэмжүүлж авна.Тэгээд л өдрийн түрш ажил хийж байгаад шөнө нэг дэн барьж байгаад л номоо цээжилнэ.Тэгээд өглөө босчихоод цай чаначихаад багшийнхаа босохын хооронд нэг харна.

Гантулга: Сэргээчихнэ?

Содномдорж: Тэгнэ.Тэгээд л шүүлгэнэ дээ.

Гантулга: Тэгээд л номоо үзээд байх уу?

Содномдорж: Тэгээд л номоо үзээд байна.

Гантулга: Энэ Өлгий хийдийн ойролцоо тийм лам нар үйлчилдэг хар ажил хийдэг улсууд байсан болов уу?

Содномдорж: Байгаагүй.

Гантулга: Лам нар өөрсдөө л бүх юмаа хийнэ?

Содномдорж: Өөрсдөө л бүх юмаа хийнэ. Шавь нар нь хийнэ, томхон ламынхыг бол.

Гантулга: Мөргөлчид ирж одоо энэ эмчид үзүүлэх гээд янз бүрийн ажил?

Содномдорж: Байлгүй дээ.

Гантулга: Хийд дээр байрладаг байсан болов уу?

Содномдорж: Байрладаггүй юм. Өлгий гороондоо бол эмэгтэй хүн оруулдаггүй юм. Одоо арван тавны орой асар их мөргөлчин ирнэ.Тэгээд тэр айлуудаар бууна.Тэгээд шөнө ч одоо мод чирсэн, дуган ч гэж зарлага нь юм уу даа.Тэр дуган чуулж хашхирна.Мөргөлчид яв гээд.Тэгэхэд л ум хумгүй яваад тэгээд хөдөө очиж унтана.

Гантулга: Ойрхон зах зээл худалдаа наймааны газар байсан болов уу?

Содномдорж: Байгаагүй. Аагент л байсан. Гэндэн гэдэг хүн аагент байсан юм.Хоргодамбадаржаагийн тэр Түмбэ гэдэг хүн багийн дарга байсан юм. Өөрөө өнөөх баг болсон юм, сүүлдээ.

Гантулга: Хятадын наймаа худалдаа гэж байсан болов уу?

Содномдорж: Урд байгаа биз дээ.Миний байх үед бол хятад ирэхээ байж байсан.

Гантулга: Хийд хэдэн онд хаагдсан бэ?

Содномдорж: 1937 оны үхэр жилийн өвлийн эхэн сарын үед.

Гантулга: Ямар хүн сумаас ирж одоо хаа барь энэ тэр гэж байсан бэ?

Содномдорж: Аймгаас аа, гартаан Дэжид гэж Өмнөговийн аймгийн даргын хожим нь арван жил хийсэн.Дэжид гэдэг хүн ирсэн. Хоёр гурван ч машин ирсэн байх.

Гантулга: Хаагдсаны дараа хийд юу болсон, лам нар нь яасан бол?



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Содномдорж: Тарж бутраад л тэгээд л уулын жалгаар гэрээ бариад л тэгээд л байж байсан.

Гантулга: Баригдах нь баригдаад л?

Содномдорж: Тэгээд л баригдах нь баригдаад.

Гантулга: Нөгөө айлуудын хаалган дээр бас янз бүрийн дугаар наагаад?

Содномдорж: Дугаар, тэр ч яахав дээ. Өлгий тарахаас өмнө, хэдэн жилийн өмнө. Айл бүрийн хаалга дугаартай, ноймортой. Одоогийн мотоциклын дугаар хаддаг шиг, тийм хэлбэрийн төмөр дээр нэрийг нь биччихсэн. Тэр гол хүний, хашааны эзний нэрийг нь биччихсэн, тийм байсан. Сүүлд нь лам нар ирж энэ дугаараар чинь шөнө бариад байдаг юм байна ш дээ, энэ чинь тийм л бэлтгэл байсан юм байна гэж ярьдаг байсан.

Гантулга: Та бол тэгээд хурал хаагдангуут?

Содномдорж: Би тэр хурал хаагдах, Өлгий хийдийн бүх лам нарыг дуудаж цуглуулсан. Тэгээд бүгдээрээ ч очсон юм уу, үгүй юм уу. Олон л лам сууж байсан. Цаныдийн жасын үүдэнд олон лам суучихсан, гадаа дэнлүү дүүжилчихсэн. Жасынх нь үүдийг дэлгэчихсэн, тэр нярав нарынх нь тэрэн дээр тэр Дэжид тэргүүтэй улсууд суугаад хурал хийлгэж хойшоо тавин км билүү дээ, санаж байна би. Тэрнээс ч хол билүү мэдэхгүй байна.

Гантулга: Нүү гээд?

Содномдорж: Нүү, нүүж чадахгүй бол тар гэсэн. Тэгээд тарах юм болж л байх шиг байсан. Тэгээд би ч өөрийнхөө хөрөнгө рүү явчихсан.

Гантулга: Тэгээд л хар болсон?

Содномдорж: Тэгсэн.

Гантулга: Та хийд хаагдсаны дараа тэгээд хар болоод ямар ажил эрхэлсэн бэ?

Содномдорж: Хийд хаагдсаны хойтон хавар нь таван сард манай эцэг баригдсан. Тэгээд хөрөнгөө аймагт хүргэж өгсөн, малаа тууж. Ачаа барааны хүн, тэмээний хүн, хонины хүн гээд лут лут олон айл хураагдчихсан, олон мал тууж өгсөн. Тэгээд хөрөнгө хураалгасны дараа намайг аагент болгосон. Би тэгээд аагент хийж байсан, манай ижий сая хөрөнгө хураалгаж нэг баларсан. Одоо чиний тэр лүү цөлөх гэж баларна даа гээд их намайг загнадаг байсан. Тэгээд гурван жил шахуу хийгээд, эсэргүүний ар гэр гээд намайг цэрэгт авч явдаггүй. Тэгээд хорин нэг хүртлээ, 1941 он хүртэл би агент хийж байхад тэгээд очсон доо, одоогоор нэг арван хоёр төгрөг төллүү дээ. Тэгээд гарсан, нэг юм нэг болж л байсан юм шиг байгаа юм.

Гантулга: Тэр хийдийн судар номыг ер нь яасан бол, сүүлдээ?

Содномдорж: Түлсэн байх аа.

Гантулга: Заримыг нь бас хүн амьтан авч нуугаад, сүүлдээ?

Содномдорж: Аа тэгсэн л юм гэсэн. Тэр Өлгийн Аръяабалыг тэр Тогообэлэн гэдэг хүн аваад Хүрэн дэлийн гэдэг уулын ард жоохон гэр бариад өөрөө тэнд суудаг байж байсан. Тэгээд адуу эрж яваад хоёр гэртэй айлд буугаадахсан тэр Тогообэлэнгийнх байсан, хуучин таньдаг, тэгээд тэр хүн намайг таних юм чинь дээ. Би Аръяабалыг аваад ирсэн. Энэ арын гэрт байж байгаа, чи мөргөх үү гээд би мөргөчихөөд явж байсан юм.

Гантулга: Бас өөр нөгөө?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Содномдорж: Сосор гэдэг хүн, Мандах сумын хүн. Гурван газар Өлгийн юмыг хулгай хийж булсан юм гэнэ лээ. Тэгээд хоёрыг нь олоод нэгийг нь энэ Өлгий хийд байгуулагдахад энэ гурван юмаа өгөх гэсэн чинь нэгийг нь олоогүй гэж. Тэр их өндөр настай ерэн хэдэн настай хүн байж байгаад үхчихсэн юм.

Гантулга: Ер нь та энэ социализмын үед жирийн ажил хийж байхдаа энэ хуучин хамт хурж байсан тэр улсуудтайгаа уулзаж, хурал номоо сэргээж хааяа ном уншдаг байсан болов уу?

Содномдорж: Үгүй ээ. Тэгсэн улс баригдаж байсан юм. Одоо энэ Хатны, Хатан сумын ахаа Дашдорж гэж багийн дарга. Аа нэг нь хэнсэн билээ дээ, нэр нь олдохгүй байна. Хоёр багийн дарга цүнхээ тайлж шидчихээд өнөө ламын нөгөө дүйцэд гэдэг байх аа. Тийм хурал хурсан юм гэнэ лээ. Манай эндхээс тэр Сономдорж гэж нэг лам байсан юм. Хориод тэмээтэй тэрнийгээ маллаад тэгээд тэр Хатан сумын наад талаар байдаг. Тэр очиж хурж, тэгээд сүүлд нь би ч албанаас халагдаад хөдөө гарсан. Тэр ламыг барих улс манайд очиж хоноод тэгээд намайг дагуулж очиж барьж байсан юм. Тэр Сономдоржийг. Тэгээд багийн дарга, хоёр багийн дарга, зүүн тушаа баригдсан. Сономдорж гуай баруун тийшээ баригдсан. Хоёр гурван жил яваад цугаараа ирсэн.

Гантулга: Өлгий хийд одоо хэдэн онд сэргэсэн бэ, ерэн онд сэргэчихсэн үү?

Содномдорж: Ерэн нэг хоёр оны үед болов уу даа.

Гантулга: Та тэгэхэд нь лам болоогүй юм уу?

Содномдорж: Болоогүй ээ. Ер нь хийд байгуулахаас өмнө тэр чинь манай нэг дүү Түвдэндорж гэдэг хүн ер нь голыг нь сэдэвлэж байгуулсан юм. Тэр ах дүүгийн хувьд надад захиа бичээд л байсан. Та ирнэ шүү гээд л байсан. Тэгээд би захиаг нь авчихаад хариу нэг ч өгөөгүй байж байгаад, яг байгуулахад нь өвөл байгуулсан юм аа. Тэгээд би очоогүй. Тийм их ном мэдэх ч биш амьтны толгой эргүүлж яахав.

Гантулга: Гээд...?

Содномдорж: Гэж бодоод, тэгээд намайг очвол заавал нэг алба өгнө. Би чинь тэгэхэд ануухан байсан байхгүй юу.

Гантулга: Тэгэлгүй яахав дээ, одоо арван хэдэн жилийн өмнө?

Содномдорж: Тийм, одоо далан хэдтэй байсан байх даа.

Гантулга: Та ярилцлага өгсөн танд их баярлалаа.

Содномдорж: За баярлалаа.

Гантулга: За баярлалаа.

Содномдорж: Ярилцлага авсан та хоёртоо баяр хүргэе. Сайн яваад ажлаа бүтээгээд хариарай.

Гантулга: За баярлалаа.